



СЭТГЭЦ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эмчилгээ, үйлчилгээний 2 шинэ арга, технологийг практикт нэгдүгээр зохиогчоор нэвтрүүлэн үр дунд хүрсэн байх /эмчилгээ эрхэлсэн орлогч даргын тодорхойлолт хавсаргах/;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны 2-оос доошгүй бүтээл нэгдүгээр зохиогчоор анагаах ухааны хэвлэлд нийтлүүлсэн байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
3. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 3 зөвлөгөө зөвлөмж /10 нүүр буюу 5-аас доошгүй хуудастай/ нэгдүгээр зохиогчоор шинээр боловсруулж хэвлүүлсэн, олон нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
4. Мэргэшлийн дагуу дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эмчилгээ, үйлчилгээний 3 шинэ арга, технологийг практикт нэгдүгээр зохиогчоор нэвтрүүлэн үр дунд хүрсэн байх /эмчилгээ эрхэлсэн орлогч даргын тодорхойлолт/;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны 3-аас доошгүй бүтээл нэгдүгээр зохиогчоор анагаах ухааны хэвлэлд нийтлүүлсэн байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
3. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 5 зөвлөгөө зөвлөмж /10 нүүр буюу 5-аас доошгүй хуудастай/ нэгдүгээр зохиогчоор шинээр боловсруулж хэвлүүлсэн, олон нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
4. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 1 гарын авлага /хэвлэлийн 5 хуудас буюу 80 нүүр ба 40-өөс доошгүй хуудастай / нэгдүгээр зохиогчоор шинээр

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

болосвруулж хэвлүүлсэн, олог нийтийн хүртээл болгосон байх / бүтээлийн эх хувь ба хуулбарын хамт бүрдүүлэх/ ;
5. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үнд:

1. Эмчилгээ, үйлчилгээний 5 шинэ арга, технологийг практикт нэгдүгээр зохиогчоор нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх /эмчилгээ эрхэлсэн орлогч даргын тодорхойполт хавсаргах /;
2. Мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг 2 ба түүнээс дээш боловсруулан батлуулсан байх /стандартын дугаар тавигдсан байх, баталгаажсан эх хуулбар /;
3. Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны 5-аас доошгүй бүтээл нэгдүгээр зохиогчоор анагаах ухааны хэвлэлд нийтлүүлсэн байх /бүтээлийн эх хувь ба хуулбарыг хамт бүрдүүлэх/;
4. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 2 гарын авлага /хэвлэлийн 5 хуудас буюу 80 нүүр ба 40-өөс доошгүй хуудастай/ нэгдүгээр зохиогчоор шинээр болосвруулж хэвлүүлсэн, олог нийтийн хүртээл болгосон байх /бүтээлийн эх хувь ба хуулбарын хамт бүрдүүлэх/;
5. Үндсэн болон төрөлжсэн мэргэшлийн сургалтад хичээл заасан, эмнэл зүйн сургач багшаар ажилласан байх /заасан хичээлийн сэдэв, цаг, хамрагдсан эмч нарын тоо баримтжуулсан материал /;
6. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад багшилсан байх, шинэ залуу эмч, мэргэжилтнүүдийг шавилан сургасан байх;
7. Тухайн мэргэжлийн салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд идэвхитэй оролцон, бодлого арга зүйн асуудлыг дэвшүүлж шийдвэрлүүлэн, удирдан зохион байгуулсан байх /тухайн үйл ажиллагааг зохион байгуулсан, эсвэл идэвхитэй оролцсон болохыг батлах баримт нотолгоо, тухайлбал удирдан зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийн эх хувь гэх мэт /;
8. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх.